



www.masd.mn

2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

“Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо”

Өөрийгөө зохицуулах байгууллагын 2024 оны үйл
ажиллагааны тайлан



АГУУЛГА



**МОНГОЛЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН
ХОЛБОО**



**ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН ЭРХ АШИГ, ХӨРӨНГИЙН ЗАХ
ЗЭЭЛИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЧИГЛЭЛЭЭР**



БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ТАЙЛАН



СУРГАЛТ СУДАЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР



**ГИШҮҮН БАЙГУУЛЛАГА, МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ЭРХ
АШИГ, ЧАДАВХЫГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР**



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭЭНД

Хөрөнгө оруулагчид болон гишүүн байгууллагуудын нийтлэг эрх ашгийг хамгаалж ёс зүйн стандартыг тогтоож шударга, ил тод, нээлттэй зах зээлийг бүрдүүлэн хөрөнгийн зах зээлийн тогтвортой хөгжлийг бий болгох зорилгын доор 2024 оны ажлын тайланг хүргэж байна.

Байгуулагдсан он:

1995

ӨЗБ болсон:

2015

Бусад улсын гишүүнчлэл:



Asia
Securities
Forum

2024 онд 10 мэргэжлийн, 5 хамтрагч гишүүн шинээр элсэж нийт 91 гишүүнтэй болов.

- “Ашид ассет менежмент ҮЦК” ХХК;
- “Инвекор ассет менежмент ҮЦК” ХХК;
- “Новел ассет менежмент ҮЦК” ХХК;
- “Юү эй эф ассет менежмент ҮЦК” ХХК;
- “Ди си эф ҮЦК” ХХК;
- “Үнэт ассет менежмент ҮЦК” ХХК;
- “Үнэт секьюритис ҮЦК” ХХК;
- “Чингис хаан хөрөнгийн бирж” ХХК;
- “Эн жи комити ҮЦК” ХХК;
- “Голомт ассет менежмент ҮЦК” ХХК;
- “Онч кредит рейтинг эйжинси” ХХК
- “Өмгөөллийн Хаанлекс партнерс” ХХН
- “Өмгөөллийн эм жэй эл атторнейс” ХХН
- “Өмгөөллийн эм энд жи лоу фирм” ХХН
- “Коммодити трейд маркетс” ХХК тус тус гишүүнээр элсүүлэв.

47

Үнэт
цаасны
компани

22

Хөрөнгө
оруулалт
менежментийн
компани

05

Дэд
бүтцийн
байгууллага

05

Банк

03

Хувьцаат
компани

01

Үнэлгээний
компани

01

Олон улсын
байгууллага

05

ҮЦЗЗ
оролцогчид
хууль зүйн
зөвлөгөө
үзүүлэх

02

Санхүүжих
чадавхын
зэрэглэл
тогтоох
байгууллага

73

МЭРГЭЖЛИЙН ГИШҮҮН БАЙГУУЛЛАГА

18

ДЭМЖИГЧ ГИШҮҮН БАЙГУУЛЛАГА

91

ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
2024 ТАЙЛАН

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



Ц.СОДХҮҮ

ГИШҮҮД:



Д.АЧИТ-ЭРДЭНЭ



Л.БИЛГҮҮН



Т.БОЛД



С.ГАН-ЭРДЭНЭ



Б.ЛХАМДОЛГОР



М.ОТГОНБААТАР



А.ӨЛЗИЙДЭЛГЭР



Г.ЭНХБАТ

ХАРААТ БУС ГИШҮҮД:



Э.ЗОЛБАЯР



А.ХУЛАН

ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
2024 ТАЙЛАН

“ 2024 онд Удирдах зөвлөлийн гишүүд нийт 17 удаа хөрөнгийн зах зээлийн цаг үеийн асуудлаар ээлжит болон ээлжит бусаар хуралдаж нийт 55 тогтоол гаргасан. ”

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ		
ОГНОО	ХУРЛЫН ТӨЛӨВ	ИРЦ
2024 оны 1 сарын 9	Ээлжит	73%
2024 оны 2 сарын 6	Ээлжит	73%
2024 оны 3 сарын 5	Ээлжит	73%
2024 оны 3 сарын 19	Ээлжит бус	81%
2024 оны 4 сарын 3	Ээлжит	100%
2024 оны 4 сарын 8	Ээлжит бус	100%
2024 оны 5 сарын 7	Ээлжит	73%
2024 оны 6 сарын 4	Ээлжит	73%
2024 оны 7 сарын 9	Ээлжит	73%
2024 оны 8 сарын 6	Ээлжит	82%
2024 оны 9 сарын 10	Ээлжит	91%
2024 оны 9 сарын 16	Ээлжит бус	82%
2024 оны 10 сарын 9	Ээлжит	73%
2024 оны 10 сарын 30	Ээлжит бус	73%
2024 оны 11 сарын 8	Ээлжит бус	91%
2024 оны 11 сарын 12	Ээлжит	82%
2024 оны 12 сарын 10	Ээлжит	91%
Хэлэлцсэн асуудал: 102 Гаргасан шийдвэр: 55		

ГАДААД ХАРИЛЦААНЫ БОДЛОГЫН ХОРООНЫ ХУРАЛ		
ОГНОО	ХУРЛЫН ТӨЛӨВ	ИРЦ
1 сарын 17	ээлжит	80%
5 сарын 9	ээлжит	100%
5 сарын 28	ээлжит	80%
8 сарын 2	ээлжит	80%

БОДЛОГЫН ХОРООНЫ ХУРАЛ		
ОГНОО	ХУРЛЫН ТӨЛӨВ	ИРЦ
1 сарын 17	Ээлжит	60%
4 сарын 12	Ээлжит	100%
5 сарын 1	Ээлжит	80%
5 сарын 9	Ээлжит	80%
6 сарын 3	Ээлжит	80%
8 сарын 27	Ээлжит	80%
9 сарын 5	Ээлжит	80%
9 сарын 12	Ээлжит	80%
9 сарын 16	Ээлжит	80%
10 сарын 29	Ээлжит	80%
12 сарын 2	Ээлжит	80%

БОЛОВСРОЛЫН ХОРООНЫ ХУРАЛ		
ОГНОО	ХУРЛЫН ТӨЛӨВ	ИРЦ
1 сарын 17	ээлжит	60%
5 сарын 1	ээлжит	100%
9 сарын 3	ээлжит	80%
9 сарын 9	ээлжит	80%
12 сарын 5	ээлжит	80%

ӨӨРИЙГӨӨ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ХУРАЛ		
ОГНОО	ХУРЛЫН ТӨЛӨВ	ИРЦ
4 сарын 15	ээлжит	80%

Удирдах зөвлөлийн баталсан журмууд:

2024/6
МҮЦАЭХ-ны дүрмийн
шинэчилсэн найруулга

2024/6
МҮЦАЭХ-ны
гишүүнчлэлийн журам

2024/6
МҮЦАЭХ-ны Удирдах
зөвлөлийн журам

2024/6
МҮЦАЭХ-ны Их хурал зохион
байгуулах журам

2024/6
МҮЦАЭХ-ны Хяналтын
зөвлөлийн журам

2024/10
МҮЦАЭХ-ны Ажлын
албаны дотоод журам



2024/10
ББЗЗ-ийн Бүртгэлийн хорооны
үйл ажиллагааны журам

2024/10
ББЗЗ-ийн үнэт цаасны
бүртгэлийн журам

ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



С.ЖАВХЛАН

ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:



Ё.АМАРБАТ



Ч.АНДСАЙХАН



С.БАЯРХҮҮ



Ч.НЯМДОРЖ



У.ЭНХТАЙВАН



Ж.ЭРДЭНЭБАТ

Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны ээлжит бус "Их хурал" 2024 оны 11-р сарын 14-ны өдөр зохион байгуулагдаж Холбооны сонгуульт албан тушаалтныг шинэчлэн сонгосон. Хяналтын зөвлөлийн сонгуульт албан тушаалд 9 хүн нэр дэвшиж, дараах нэр дэвшигчид олонхын саналаар сонгогдлоо.

ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ		
ОГНОО	ХУРЛЫН ТӨЛӨВ	ИРЦ
9 сарын 5	ээлжит	100%
9 сарын 30	ээлжит бус	67%
12 сарын 5	ээлжит бус	86%



Бүх гишүүдийн ИХ ХУРАЛ 2024

XXV

Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны XXV "Их хурал" 2024 оны 3-р сарын 27-ны өдөр зохион байгуулагдлаа. Холбооны дүрмийн 18.2-т заасны дагуу саналын эрхтэй 67 мэргэжлийн гишүүдээс 62 гишүүн байгууллага оролцсоноор 92,53 %-ийн ирцтэй хурал боллоо.

Их хурлын тэргүүлэгчдийн бүрэлдэхүүнд:

- Ц.Наран-Учрал / Ди Эйч Капитал ҮЦК ХХК;
- К.Алия / Таван богд ҮЦК ХХК;
- У.Энхтайван / Гүүдсек ҮЦК ХХК нар,

Их хурлын тооллогын комиссын бүрэлдэхүүнд:

- Г.Мөнх-Эрдэнэ / Таванбогд капитал ҮЦК ХХК;
- Ё.Амарбат / Стокларб секьюритиз ҮЦК ХХК;
- М.Даваажаргал / Улаанбаатар Үнэт Цаасны Бирж ҮЦК ХХК нар сонгогдон ажиллалаа.

Их хурлаар Холбооны Удирдах зөвлөл, бусад хороод, зөвлөл 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, 2024 оны ерөнхий төлөвлөгөө, төсөв танилцуулж, Холбооны сонгуульт албан тушаалтныг шинэчлэн сонголоо. Сонгуульт 22 албан тушаалд 40 хүн нэр дэвшиж, дараах нэр дэвшигчид олонхийн саналаар сонгогдлоо.

Удирдах зөвлөлийн гишүүд:

- Д.Ачит-Эрдэнэ
- Л.Билгүүн
- Т.Болд
- С.Ган-Эрдэнэ
- Б.Лхамдолгор
- М.Отгонбаатар
- А.Өлзийдэлгэр
- Г.Энхбат

Удирдах зөвлөлийн хараат бус гишүүд:

- Э.Золбаяр
- Ц.Содхүү
- А.Хулан

Хяналтын зөвлөлийн гишүүд:

- С.Баярхүү
- Э.Хоролсүрэн
- У.Энхтайван

Ёс зүйн хорооны гишүүд:

- А.Батболд
- Г.Маргад
- С.Өнөр

Сахилгын зөвлөлийн гишүүд:

- Ч.Андсайхан
- Б.Батсүрэн
- Д.Ганзориг
- Т.Хаш-Эрдэнэ
- Б.Хулан



Бүх гишүүдийн ээлжит бус ИХ ХУРАЛ 2024

Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны ээлжит бус “Их хурал” 2024 оны 6-р сарын 14-ний өдөр зохион байгуулагдлаа. Холбооны дүрмийн 18.2-т заасны дагуу саналын эрхтэй 67 мэргэжлийн гишүүдээс 35 гишүүн байгууллага оролцсоноор 52,23 хувийн ирцтэй хурал боллоо.

Их хурлын тэргүүлэгчдийн бүрэлдэхүүнд:

- Б.Өлзийбаяр / Өлзий энд ко капитал ҮЦК ХХК;
- Б.Лхагвадорж / БиДиСЕК ҮЦК ХХК;
- Ч.Нямдорж / Масдак ҮЦК ХХК нар,

Их хурлын тооллогын комиссын бүрэлдэхүүнд:

- Д.Баатаржав / Мазаалай капитал партнерс ҮЦК ХХК;
- Б.Мөнгөнзул / Ти Ди Би секьюритис ҮЦК ХХК;
- О.Энхманлай / Тэнгэр капитал ҮЦК ХХК нар сонгогдон ажиллалаа.
-

Ээлжит бус “Их хурал”-аар дараах дүрэм журмуудын шинэчилсэн найруулгыг баталлаа.

- Холбооны “Дүрэм”;
- “Гишүүнчлэлийн журам”;
- “Удирдах зөвлөлийн журам”;
- “Хяналтын зөвлөлийн журам”.

Ээлжит бус “Их хурал”-аар дараах журмыг шинээр баталлаа.

- “Их Хурал зохион байгуулах журам”.

Журмуудыг Санхүүгийн зохицуулах хороогоор батлуулж, Холбооны “Дүрэм”-ийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлснээр хүчин төгөлдөр мөрдөгдөх болно.



Бүх гишүүдийн ээлжит бус ИХ ХУРАЛ 2024

Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны ээлжит бус "Их хурал" 2024 оны 11-р сарын 14-ны өдөр зохион байгуулагдлаа. Их хурал зохион байгуулах журмын 2.8-т заасны дагуу саналын эрхтэй 72 мэргэжлийн гишүүдээс 40 гишүүн байгууллага оролцсоноор 55.5%-ийн ирцтэй хурал боллоо.

Их хурлын тэргүүлэгчдийн бүрэлдэхүүнд:

- Л.Билгүүн / Инвекор Капитал ҮЦК ХХК;
- Г.Энхбат / Ти Ди Би Секюритис ҮЦК ХХК;
- А.Өлзийдэлгэр / Мандал капитал маркетс ҮЦК ХХК нар,

Их хурлын тооллогын комиссын бүрэлдэхүүнд:

- Б.Орчлон / Эс Жи инвестмент энд секьюритис ҮЦК ХХК;
- Б.Мөнгөнзул / Инвекор ассет менежмент ҮЦК ХХК;
- Б.Хулан / Бумбат алтай ҮЦК ХХК нар сонгогдон ажиллалаа.

Их хурлаар гишүүд Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны эхний 6 сарын тайлан болон Холбооны шинэчлэгдсэн лого, брэндбүүктэй танилцсан. Мөн дараах дүрэм журмуудын шинэчилсэн найруулгыг баталлаа.

- Монголын хөрөнгийн зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ үзүүлэгчдийн баримтлах ёс зүйн дүрэм;
- Холбоо, түүний гишүүдийн үйл ажиллагаанд хяналт тавих, гомдол, маргааныг хянан шийдвэрлэх журам;
- Гишүүнчлэлийн хураамжийг нэмэгдүүлэх зорилгоор Холбооны Гишүүнчлэлийн журмын хавсралтад өөрчлөлт орууллаа.

Дүрэм, журмуудыг Санхүүгийн зохицуулах хороогоор батламжлуулснаар хүчин төгөлдөр мөрдөгдөх болно.

Их хурлаар Холбооны сонгуульт албан тушаалтныг шинэчлэн сонголоо.

Хяналтын зөвлөлийн сонгуульт албан тушаалд 9 хүн нэр дэвшиж, дараах нэр дэвшигчид олонхын саналаар сонгогдлоо.

1. Ё.Амарбат (Стоклаб секьюритиз ҮЦК ХХК-ийн гүйцэтгэх захирал)
2. Ч.Андсайхан (МҮЦКТ-ийн клиринг эрсдэлийн удирдлагын албаны захирал)
3. С.Баярхүү (Монголын үндэсний тайлагнал аудит ХХК-ийн Аудит партнер, Зөвлөх үйлчилгээ хариуцсан захирал)
4. С.Жавхлан (Өмгөөллийн Номадикс Бизнес Лоу Фирм ХХК-ийн партнер, өмгөөлөгч)
5. Ч.Нямдорж (Масдак ҮЦК ХХК-ийн Гүйцэтгэх захирал)
6. У.Энхтайван (Гүүдсек ҮЦК ХХК-ийн Гүйцэтгэх захирал)
7. Ж.Эрдэнэбат (Тэргэл прайм пропертиз ХХК-ийн Гүйцэтгэх захирал)



ЛОГО ШИНЭЧЛЭГДЛЭЭ 2024

Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо 1995 онд үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш логогоо өөрчилгүйгээр ашиглаж ирсэн билээ. Дотоод гадаадын бизнесийн байгууллагуудын жишгээр зах зээлийн өрсөлдөөн, өөрчлөлт эрчимжиж буй энэ цаг үед Холбоо нь өөрийн логог шинэчлэхээр шийдвэрлэж, нийт гишүүн байгууллагууд болон мэргэжилтнүүдийнхээ дунд лого бүтээх уралдаан зарласан.

Уралдаанд шалгарсан логоны үндсэн санаа, шийдлийг суурь болгон мэргэжлийн түвшинд сайжруулсан шинэ логог нэвтрүүлсэн.

Шинэ логоны гурван дээш чиглэсэн зураас нь туг далбаа байдлаар харагдах бөгөөд эдгээр нь Засаглал, Түншлэл, Өсөлт-г бэлгэдэн Хөгжилд тэмүүлэх үзэл санааг илтгэнэ. Логоны үндсэн өнгө болох хар хөх өнгө нь найдвартай, мэргэжлийн байдлыг тодотгож байна.

Шинэчлэгдсэн лого нь Холбооны эрхэм зорилго, үнэт зүйлс болон цаашдын хөгжлийн төлөвлөгөөг илэрхийлж, гишүүд болон олон нийтэд байгууллагын үнэ цэнэ, зорилгыг ойлгуулахад чиглэгдсэн байна.



Азийн үнэт цаасны форумын XXIX-дах чуулга уулзалт япон улсын токио хотод зохион байгуулагдлаа.

2024



Япон улсын Токио хотноо 2024 оны 10-р сарын 22-ноос 24-ний хооронд зохион байгуулагдсан тус форумд Asia Securities Industry & Financial Markets Association (ASIFMA), International Capital Market Association (ICMA), International Council of Securities Association (ICSA), International Organization of Securities Commissions (IOSCO) болон Азийн 20 гаруй улсын зочид төлөөлөгчид оролцлоо.

Тус форумд Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоог төлөөлөн Удирдах зөвлөлийн дарга Ц.Содхүү, Удирдах зөвлөлийн гишүүн Э.Золбаяр, Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Буянхишиг, Гишүүд, хамтын ажиллагаа хариуцсан захирал Э.Мөнх-Өргөө нар оролцож Монгол Улсын зах зээлийн тойм, хөрөнгийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдлын талаар илтгэл тавьж, сурталчлан танилцууллаа.

Форум нь Азийн бүс нутгийн зах зээлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, тогтвортой хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх зорилготой бөгөөд энэ жилийн чуулга уулзалт "Ногоон санхүүжилт ба дижитал шилжилт" гэсэн урианы дор болсон юм. Үүний хүрээнд оролцогчид ногоон санхүүжилт болон дижитал шилжилтийн бодлого, стратегийн талаар хамтран хэлэлцэж, ирээдүйн чиг хандлагуудыг тодорхойллоо.

Монгол Улс ногоон санхүүжилтийн хүрээнд томоохон алхмуудыг хэрэгжүүлж байгаа бөгөөд үүнд "Ногоон ангилал"-ын баталгаа, тогтвортой хөгжлийн зорилтуудад нийцсэн санхүүгийн системийг хөгжүүлэх ажлууд багтаж байна. Түүнчлэн Монгол Улс дижитал шилжилт, хөрөнгийн зах зээлийн шинэчлэлийн хүрээнд блокчейн технологийг ашиглан үнэт цаасны арилжаанд цахим системийг туршиж байгаа талаар Холбооны төлөөлөгчид чуулганы үеэр танилцууллаа.

Мөн 2025 онд Азийн үнэт цаасны форумын 30 дахь чуулга уулзалтыг Улаанбаатар хотноо анх удаа Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо зохион байгуулахаар болсныг зарлалаа.

Энэ нь Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжлийн том илрэл бөгөөд Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо үүсгэн байгуулагдсаны 30 жилийн ойтой давхцах томоохон ач холбогдолтой үйл явдал болох юм.

•
ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН ЭРХ АШИГ, ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН
ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЧИГЛЭЛЭЭР
•

The MASD logo is embossed in silver on a red textured surface. It features a stylized 'M' symbol followed by the letters 'A', 'S', and 'D' in a bold, sans-serif font. A thin white line with a circle at its end extends from the left edge of the red area towards the logo.

MASD



Хөрөнгө оруулагчдын эрх ашиг, хөрөнгийн зах зээлийн тогтвортой хөгжлийн чиглэлээр 2024

Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимтай уулзалт зохион байгууллаа.



Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо нь Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимтай уулзалт зохион байгуулж дараах асуудлуудыг хэлэлцлээ.

- Хувийн хэвшлийн байгууллагуудын эдийн засгийн тогтвортой хөгжилд оруулж буй хувь нэмрийг нэмэгдүүлэх, компаниудыг нээлттэй болгох замаар компанийн засаглалыг сайжруулах, тогтвортой хөгжлийг дэмжих;
- Бизнес эрхлэх нөхцөл боломж, хууль эрх зүй, татварын таатай орчныг бий болгох;
- Төрийн бус байгууллага болон мэргэжлийн институциудын нийгэм, эдийн засаг дах үүрэг, оролцоог бэхжүүлэх гэсэн чиглэлүүдээр хамтран ажиллахаар ярилцлаа.



Хөрөнгө оруулагчдын эрх ашиг, хөрөнгийн зах зээлийн тогтвортой хөгжлийн чиглэлээр

“Тогтвортой байдал, хүрээлэн буй орчин, уур амьсгалын тайлагнал” хэлэлцүүлэг



Санхүүгийн зохицуулах хороо, ToC Холбоо, Монголбанк хамтран “Тогтвортой байдал, хүрээлэн буй орчин, уур амьсгалын тайлагнал” сэдэвт хэлэлцүүлэг, арга хэмжээг зохион байгууллаа. Уг арга хэмжээнд Мэргэжлийн холбоодын төлөөлүүд болон ToC Холбооны гишүүн байгууллагуудын Тогтвортой байдал, Санхүү байдлын Тайлагналын үйл ажиллагаа хариуцсан дунд болон дээд түвшний удирдлага, ажилтнууд, Биржид бүртгэлтэй топ компаниуд, санхүүгийн салбарын зохицуулагч, бодлогын байгууллагуудын 140 гаруй төлөөлөгч нар оролцлоо.

Арга хэмжээ нь тогтвортой байдал ба хүрээлэн буй орчин, уур амьсгалын тайлагналын сургалтаар дэлхий даяар хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй тогтвортой байдал, хүрээлэн буй орчин, уур амьсгалын тайлагналын стандартуудын олон улсын чиг хандлага, хэрэгжилтийн талаар мэдээлэл өгөх, Монгол компаниудын туршлага, сургамж, бэрхшээл, цаашдын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилготой хэлэлцүүлгүүд өрнөсөн. Арга хэмжээний нээлтийн үеэр Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга Т.Жамбаажамц нь хэлсэн үгэндээ 2022 онд “Байгаль орчин нийгэм, засаглал (БОНЗ), Тогтвортой байдлын тайлагналын удирдамж”-ийг боловсруулж, баталснаар нээлттэй хувьцаат компаниуд, үнэт цаас гаргагчид болон бизнесийн салбарын байгууллагууд сайн дурын үндсэн дээр тайлагналаа гаргадаг болсон бөгөөд 2022-2023 онд 11, энэ оны нэгдүгээр улирлын байдлаар 7 хувьцаат компани БОНЗ-ын тайлангаа олон нийтэд танилцуулаад байна. Жил ирэх тусам тайлагналын удирдамжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж тайлагнадаг, ач холбогдол өгч ажилладаг компаниудын тоо өснө гэдэгт итгэлтэй байна хэмээн онцолсон юм.

Холбоо нь Монгол Улсын тогтвортой байдал, хүрээлэн буй орчин, уур амьсгалын тайлагналын тогтолцоог сайжруулахад чиглэсэн олон талт санаачилга, төсөл, хөтөлбөрүүдийг дэмжиж, хамтын ажиллагааг өргөжүүлэхээр ажиллаж байна.



Хөрөнгө оруулагчдын эрх ашиг, хөрөнгийн зах зээлийн тогтвортой хөгжлийн чиглэлээр

2024

Улс төрийн намуудын мөрийн хөтөлбөрт тусгах бодлогын санал, уриалга



Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо нь Capital Market's Mongolia (CMM)-тай хамтран үнэт цаасны зах зээл, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах зорилгоор 2024 оны УИХ-ын ээлжит сонгуульд өрсөлдөх намуудын мөрийн хөтөлбөрт тусгах бодлогын санал, уриалгыг боловсруулан дараах намуудад гардуулан өгсөн юм.

- ХҮН нам /2024.03.13/
- Монгол Ардын Нам /2024.03.18/
- Ардчилсан Нам /2024.03.18/

Хөрөнгийн зах зээл (ХЗЗ) Монголын хамгийн хурдтай хөгжиж буй салбаруудын нэг билээ. Ялангуяа, 2021 онд дэлхийн хамгийн өндөр өсөлттэй зах зээл болсон. Сүүлийн 3 жилд л гэхэд топ-5 банкны IPO хийгдэж ₮443 тэрбумыг зах зээлээс босгож, биржийн бус зах зээл үүсэж компаниуд зах зээлээс 2 жилийн дотор ₮1.7 их наядын санхүүжилтийг бондоор татан төвлөрүүлж, уул уурхайн бүтээгдэхүүнүүд хөрөнгийн бирж дээр амжилттай арилжаалагдаж байна. Улмаар, МХБ-д бүртгэлтэй хувьцаат компаниуд 2023 оны ашгаасаа ₮799 тэрбумын ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэдээ хуваарилахаа зарлаад буй.

Монголын ХЗЗ-ийн нийт үнэлгээ 2023 оны байдлаар ₮11.6 их наяд хүрсэн бол ДНБ ₮68.9 их наяд хүрч улмаар ХЗЗ-н ДНБ-д харьцуулсан харьцаа 16.8% болсон. Тэгвэл дэлхийн дундаж нь ХЗЗ-ийн хэмжээ ДНБ-тэйгээ тэнцүү хэмжээнд байдаг. Үүнээс харахад Монголын ХЗЗ дөнгөж хөгжлийнхөө гараан дээр байна.

Нөгөө талаас, ХЗЗ нь баялгийн тэгш хуваарилалтын механизмыг бий болгож дундаж давхаргыг дэмжиж байдгаас гадна компанийн зохистой засаглал, авлигын эсрэг ил тод байдлыг үүсгэдэг чухал салбар юм.

Иймд монголын ХЗЗ-г хөгжүүлж дараагийн шатанд гаргах боломж, хэрэгцээ шаардлага үүсээд байна. Харин ХЗЗ-г олон улсын стандартын дагуу жинхэнэ утгаар нь хөгжүүлэхийн төлөө салбарын мэргэжлийн оролцогчид улс төрийн намуудад мөрийн хөтөлбөртөө тусгах бодлогын дараах саналуудыг уриалга болгон хүргэж байна.

1. Төрийн өмчөөс олон нийтийн өмч рүү...

Төрөөс хамааралтай компаниуд, сангуудыг үе шаттайгаар ХЗЗ-д гаргаж ил тод байдал, зохистой засаглалыг бий болгоё.

- Төрийн өмчит компаниудыг үе шаттайгаар бэлдэж олон нийтийн компани болгох.** Төрийн өмчит компаниуд шууд хувьцаат компани болоход санхүүгийн болон засаглалын хувьд бэлэн биш байна. Иймд, төрийн өмчит компаниудыг IPO хийхэд үе шаттайгаар бэлдэх замаар IPO хийлгэж олон нийтийн компани болгох.
- Уул уурхайн компаниудыг ХЗЗ-д гаргах.** Монгол Улс уул уурхайд түшиглэсэн эдийн засагтай хэр нь ХЗЗ дээр ердөө ганц л уул уурхайн компанийн IPO хийгдсэн байна. Энэ нь маш хангалтгүй тоо юм. Уул уурхайн компаниудыг ХЗЗ дээр гаргах замаар ил тод байдал, баялгийн тэгш хуваарилалтыг дэмжих.
- Төрийн сангуудыг ХЗЗ-тэй холбох.** Тэтгэврийн санг төрийн 100% мэдлээс гаргаж олон улсын жишгийн дагуу хувийн тэтгэврийн сангуудыг үүсгэх хэрэгцээ мөн боломж үүсээд байна. Мөн үүнтэй зэрэгцээд хөндлөнгийн, зохистой хөрөнгийн удирдлагатай баялгийн санг үүсгэж Монголын ХЗЗ-г дараагийн шатанд гарахад зайлшгүй шаардлагатай байгаа институционал хөрөнгө оруулагчдыг бий болгох.

2. Зохицуулалтаас бодлогын дэмжлэг рүү...

Хөрөнгийн зах зээл нь хамгийн нарийн зохицуулалттай салбаруудын нэг бөгөөд ил тод тайлагнал нь эргээд том зохицуулалт болдог. Тэгвэл нөгөө талаас аливаа зах зээлд өргөжин тэлэхийн тулд оролцогчид талуудыг хөшүүрэгдэх том шаардлага үүсдэг.

- Бизнесүүдэд хувьцаат компани болох бодит хөшүүргийг бий болгох.** IPO хийж хувьцаат компани болох нь ХХК байхаас юугаар давуу талтай вэ? Тухайлбал, татварын олон төрлийн хөшүүрэг байх боломжтой. ХЗЗ-н хөгжлийн эхэн үед үүн дээр тодорхой хөшүүрэг байх зайлшгүй шаардлагатай байдаг.
- Хувьцаа, бонд эзэмших хөшүүргийг бий болгох.** Зах зээл нь хөрөнгийн урсгал, шилжилт байдаг бөгөөд хөрөнгө хамгийн өгөөжтэй, эрсдэл багатай салбарыг эрэлхийлж байдаг. Иргэд, бизнесүүдийг ХЗЗ-д оролцох оролцоог нэмэгдүүлэхийн тулд зайлшгүй бодлогын хөшүүргүүдийг бий болгох хэрэгтэй.
- ХЗЗ-ийн дэд бүтцийг сайжруулах.** Төрийн гол чиг үүрэг нь эмнэлэг, зам, гүүр зэрэг дэд бүтцийг бий болгох байдагтай адил ХЗЗ-д ч гэсэн төрөөс ХЗЗ-ийн дэд бүтцийг дараагийн шатанд гаргахад шаардлагатай санхүүжилтийг гаргаж дэмжих цаг нь болжээ.
- Зохицуулалтын давхардлыг арилгах.** Татварын болон компанийн олон төрлийн хууль, зохицуулалтууд давхардаж улмаар энэ нь эргээд хөрөнгө оруулагчдад тодорхойгүй байдлыг үүсгэж байна.
- Жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хангуулах.** Жижиг хувьцаа эзэмшигчид саналын эрх цөөн тул компанийн шийдвэрт нөлөөлөх боломж тэдэнд бага. Шийдвэрийг том хувьцаа эзэмшигчид л гаргадаг. Иймд жижиг хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл авах эрх, гомдол гаргах эрхийг өргөн хүрээнд хуульчилж, бодитоор хэрэгжүүлэх нь чухал байна.

Энэхүү уриалгыг бид Монголын бүх улс төрийн намуудад нээлттэй хүргүүлж ирэх 2024 оны УИХ-ын сонгуулийн мөрийн хөтөлбөртөө тусгахыг уриалж байна.

Монгол Улсын хөгжил дэвшилд ХЗЗ чухал үүрэгтэй гэдэгтэй санал нэгдэж ХЗЗ-г хөгжүүлэх тодорхой зорилтуудыг дэвшүүлнэ гэдэгт бид найдаж байна.



Хөрөнгө оруулагчдын эрх ашиг, хөрөнгийн зах зээлийн тогтвортой хөгжлийн чиглэлээр

2024

→ "Банкны хувьцаа эзэмшигчийн эрх болон үүрэг" сэдэвт хэлэлцүүлэг



Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо нь Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын банкны холбоотой хамтран "Банкны хувьцаа эзэмшигчийн эрх болон үүрэг" сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

Тус арга хэмжээнд "Банкны хувьцаа эзэмшигч эрхээ хэрэгжүүлэхэд тулгарч буй хүндрэл", "Банк компанийн хэлбэрээ өөрчлөн нээлттэй хувьцаат компани болсноор үүсэж буй бэрхшээл", "Банкны хувьцаа эзэмшигчийн үүрэг" сэдэвт хэлэлцүүлгүүдийг өрнүүлсэн бөгөөд "Банкны хувьцаа эзэмшигчийн эрх" сэдвийн хүрээний хэлэлцүүлэгт Холбооны Удирдах зөвлөлийн төлөөллүүд оролцлоо.

MASD ESG WEBINAR JOINED BY SUSTAINABLE FITCH

Introduction to sustainable finance market and instruments



Хөрөнгө оруулагчдын эрх ашиг, хөрөнгийн зах зээлийн тогтвортой хөгжлийн чиглэлээр

2024

Fitch Ratings

Тогтвортой санхүүгийн хүрээнд Fitch Group-ийн Sustainable Fitch байгууллагатай хамтарсан вебинар

Монгол Улсын Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт, Алсын хараа 2050, Тогтвортой санхүүгийн үндэсний замын зураг зэрэг бодлогын хүрээнд дэвшүүлсэн зорилтуудыг хангах зорилгоор Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны гадаад харилцаа хамтын ажиллагааг хангаж Fitch Group -ийн Sustainable Fitch байгууллагатай хамтарсан вебинарыг зохион байгууллаа.

Вебинарыг үзэх:





Хөрөнгө оруулагчдын эрх ашиг, хөрөнгийн зах зээлийн тогтвортой хөгжлийн чиглэлээр



“Mongolian Capital Market Connectivity 2024”-БНСУ СӨҮЛ

Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо нь Санхүүгийн зохицуулах хороо болон Санхүүгийн хөрөнгө оруулалтын холбоотой хамтран БНСУ-ын Сөүл хотноо “Mongolian Capital Market Connectivity 2024” арга хэмжээг 11-р сарын 18-20-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Арга хэмжээнд Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал, Монгол Улсаас БНСУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд С.Сүхболд, Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны Удирдах зөвлөлийн дарга Ц.Содхүү, Санхүүгийн хөрөнгө оруулалтын холбооны дарга Со Юү Сог болон хоёр орны мэргэжлийн оролцогч компаниуд, хөрөнгө оруулагчид оролцов.

Арга хэмжээнд Холбооны гишүүн байгууллагуудын төлөөллүүд Монгол Улсын эдийн засаг, хөрөнгө оруулалтын орчин, уул уурхай, эрчим хүч, банк санхүүгийн салбарт хөрөнгө оруулах сэдвээр илтгэл тавьж, мэдээлэл хийсэн бол БНСУ-ын талаас хөрөнгө оруулагч, мэргэжлийн оролцогчид өргөнөөр оролцож цаашдын хамтын ажиллагааныхаа талаар санал солилцлоо. Холбоо нь Санхүүгийн зохицуулах хороотой хамтран гадаадын хөрөнгө оруулалтыг татах, дотоодын зах зээлийг олон улсад таниулах зорилгоор Япон, Хонгконг, Шанхай, Сингапур улсуудад амжилттай айлчлалуудыг зохион байгуулсан. Энэ удаа БНСУ-ын айлчлалаар Монголын хөрөнгийн зах зээлийн боломжуудыг Солонгос улсын хөрөнгө оруулагчдад таниулж, хамтын ажиллагааны шинэ боломжуудыг нээлээ.



Хөрөнгө оруулагчдын эрх ашиг, хөрөнгийн зах зээлийн тогтвортой хөгжлийн чиглэлээр

Хөрөнгийн зах зээлийн талаар мэдээлэл өгөх нэг цэгийн үйлчилгээ



Санхүүгийн зохицуулах хороо, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Хөрөнгийн бирж болон үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа явуулж буй андеррайтерийн компаниудын төлөөлөл хамтран “ТОП-100” аж ахуйн нэгжүүдэд хөрөнгийн зах зээлийн талаар мэдээлэл өгөх “Нэг цэгийн үйлчилгээ” зохион байгууллаа.

Энэ үеэр компаниудын хөрөнгийн зах зээлд хувьцаа, бонд гаргахад тулгарч буй хүндрэл, бэрхшээлийг шийдвэрлэх, нээлттэй компани болсноор үүсэх давуу тал ач холбогдол болон IPO хийх үйл явц, дараалал, компанийн засаглалын талаар цогц мэдээллийг өгсөн юм.



Хөрөнгө оруулагчдын эрх ашиг, хөрөнгийн зах зээлийн тогтвортой хөгжлийн чиглэлээр

2024

Эдийн засгийн сэтгүүлч нарт мэдээлэл өгөх өглөөний уулзалт



Холбооны Удирдах зөвлөлийн дэргэдэх "Уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр арилжаалах тухай хуулийг хэрэгжүүлэх, уул уурхайн брокеруудын эрх ашгийг хамгаалах ажлын хэсэг"-ийн төлөөлөл "Монгол Улсын эдийн засаг ба Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа" сэдвийн хүрээнд эдийн засгийн сэтгүүлчидтэй уулзалт зохион байгууллаа.

Уулзалтаар Монгол Улсын Макро эдийн засгийн нөхцөл байдал, уул уурхайн биржийн арилжааны үйл явц түүнд тулгарч буй асуудал зэрэг сэдвийн хүрээнд нээлттэй чөлөөлт уулзалт боллоо.

Уг уулзалтын зорилго нь эдийн засгийн чиглэлээр дагнан ажилладаг сэтгүүлч нарт уул уурхайн биржийн талаарх ойлголтыг цогцоор өгөх байсан ба сэтгүүлч нарын зүгээс зөвхөн уул уурхайн биржийн арилжааны гадна бусад санхүү, эдийн засагтай холбоотой асуултыг хөндсөн уулзалт боллоо.

Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо нь цаашид уг уулзалтыг тогтмол хийж, хөрөнгийн зах зээлийн талаарх мэдээллийг эдийн засгийн сэтгүүлчдэд хүргэн ажиллах болно.

БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ТАЙЛАН





Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны чиглэлээр

2024

Санхүүгийн зохицуулах хорооноос Зохицуулалтын сэндрокс орчны журам баталлаа.



Санхүүгийн зохицуулах хорооны Сэндроксын зөвлөлийн тавдугаар хуралдаанаар ББЗЗ-ийн блокчэйн арилжааны системийг хэлэлцэж сэндрокс зохицуулалтын орчинд нэг жилийн хугацаатай туршихаар болсон. Үүний дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос 2014 оны 373 дугаар тогтоолоор баталсан "Үнэт цаасны зах зээлийн өөрийгөө зохицуулах байгууллага болон зохицуулалттай этгээдийн дүрэм, журмыг батламжлах, бүртгэх тухай заавар"-ын 3.1, 3.2 дахь хэсгийг үндэслэн "Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо" ӨЗБ-ын Удирдах зөвлөлийн 2024 оны 1-р сарын 09-ний өдрийн 24/02 дугаар тогтоолоор баталсан "Биржийн бус зах зээлийн зохицуулалтын сэндрокс орчин дахь үнэт цаасны бүртгэл арилжааны түр журам"-ыг 2024 оны 2-р сарын 06-ны өдөр баталлаа.

Биржийн бус зах зээлийн арилжаанд блокчэйн системийг нэвтрүүлснээр үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаа, төлбөр тооцоог автоматаар, тархмал технологитой, ухаалаг гэрээгээр цагийн хязгаарлалтгүй 24/7 гүйцэтгэх боломж бүрдэх юм.

Зохицуулалтын сэндрокс орчин дахь үнэт цаасны арилжаа амжилттай хийгдлээ.

Биржийн бус зах зээлд 2023 оны 12-р сарын 14-ний өдрийн 23/107 тоот тогтоолоор бүртгэгдсэн "ЛэндМН ББСБ" ХХК-ийн Лэнд бонд-1 өрийн хэрэгслийн 5 тэрбум бүхий 3 транч, 2023 оны 7-р сарын 07-ны өдрийн 23/59 тоот тогтоолоор бүртгэгдсэн "Тера Анлимитед" ХХК-ийн Тера бонд-3 өрийн хэрэгслийн 5 тэрбум төгрөг бүхий 2 транч өрийн хэрэгслүүдийн анхдагч зах зээлийн арилжаа амжилттай хийгдсэн тул андеррайтер компани болон үнэт цаас гаргагчийн хүсэлтийн дагуу 2024 оны I-р улиралд блокчэйн арилжааны системд шилжүүлж, 2024 оны 4-р сарын 05-ны өдөр хоёрдогч зах зээлийн анхны арилжаанууд амжилттай хийгдээд байна.

Блокчэйн технологийг зах зээлд бүрэн шилжих хүсэлтийг СЗХ-ны Сэндроксын албанд хүргүүлээ.

Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 11-р сарын 17-ны өдрийн 491 тоот тушаалын дагуу "Сэндрокс зохицуулалтын орчин"-д орох зөвшөөрөл авсан. Энэхүү зөвшөөрлийн хүрээнд блокчэйн арилжааны системийг 1 жилийн хугацаанд амжилттай туршиж, технологийн хувьд бэлэн болсон гэж үзэж, үндсэн зах зээлд бүрэн нэвтрүүлэх хүсэлт болон үр дүнгийн тайланг 2024 оны 12-р сарын 16-ны өдөр Сэндроксын албанд хүргүүлээ.



Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны чиглэлээр

2024

Биржийн бус зах зээлийн шууд оролцогчдын уулзалт



Биржийн бус зах зээлийн шууд оролцогч байгууллагуудын удирдах ажилтнуудад 2024 оны 5-р сарын 29-ний өдөр санхүүгийн зохицуулах хорооны санхүүгийн хүртээмжийн танхимд уулзалт зохион байгуулсан. Уг уулзалтаар ББЗЗ-н ерөнхий тойм мэдээлэл, "ББЗЗ-н Үнэт цаасны бүртгэлийн журам"-д оруулах нэмэлт өөрчлөлт, "Бүртгэлийн хорооны үйл ажиллагааны журам"-ын хэлэлцүүлэг, болон Монголын хөрөнгө оруулалтын зэрэглэлийн эжинси ХХК-иар гүйцэтгүүлсэн Барилга, ББСБ-н салбарт хийсэн судалгааны үр дүнг танилцуулах зэрэг асуудлуудын хүрээнд хэлэлцлээ.

Мөн 2024 оны 8-р сарын 29-ний өдөр Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, Үнэт цаасны газар болон ББЗЗ-ийн бүртгэлийн нэгж хамтран ББЗЗ-ийн шууд оролцогч байгууллагуудын удирдах албан тушаалтнууд болон Бүртгэлийн хорооны гишүүдийн дунд "Хаалттай хүрээнд гаргаж буй үнэт цаасны мэдээллийг нийтэд мэдээлэх" сэдвээр уулзалт зохион байгуулсан. Уг уулзалтаар ББЗЗ-ийн ерөнхий төлөв байдал болон хаалттай хүрээнд гаргаж буй үнэт цаасны мэдээллийг хаалттай хүрээнд мэдээлэхтэй холбоотой асуудлуудыг хэлэлцэв. Түүнчлэн, оролцогчид "Биржийн бус зах зээл дээр бүртгэгдсэн үнэт цаасыг олон нийтэд мэдээлэх заавар"-ыг дагаж мөрдөн ажиллах талаар нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлж, санал солилцлоо.



Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны чиглэлээр

2024

OTC Markets Group хонх цохих ёслол.



Нью-Йорк хотноо зохион байгуулагдсан Монголын хөрөнгө оруулалтын долоо хоногийн үеэр Холбооны төлөөлөгчид дэлхийн санхүүгийн түншүүд, OTC Markets Group-тэй Монголын биржийн бус зах зээл болон цаашдын хөгжлийн хандлагыг танилцуулах хэлэлцүүлэг өрнүүллээ.

Энэхүү арга хэмжээ нь хоёр байгууллагын харилцан ойлголцол, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой төдийгүй Монголын хөрөнгийн зах зээлийн мэргэжилтнүүдийн чадавхыг дээшлүүлэх, Монголын компаниудыг Америкийн нэгдсэн улсын OTC зах зээлд бүртгүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хил дамнасан хамтын ажиллагааг хөгжүүлэх, түншлэлийн харилцааг бий болгох гэх мэт олон чиглэлээр хамтран ажиллах боломжийг бүрдүүлж байгаа чухал алхам болсон юм.

Холбоо болон OTC Markets Group нь ирээдүйд хамтран ажиллах, хөрөнгө оруулагчдын ашиг сонирхлыг нэмэгдүүлэх, зах зээлийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн боломж байгааг онцолсон юм.



Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны чиглэлээр

2024

Газар дээрх хяналт, шалгалт



Холбооны Удирдах зөвлөлийн 2024 оны 7-р сарын 09-ний өдрийн 24/33 дугаартай тогтоолоор баталсан “Биржийн бус зах зээлийн үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд газар дээрх хяналт шалгалт хийх удирдамж”-ийн дагуу, биржийн бус зах зээл дээр үнэт цаас гаргахад зуучлалын үйлчилгээ үзүүлсэн 13 андеррайтерийн эрх бүхий компани болон биржийн бус зах зээл дээр олон удаа өрийн хэрэгсэл гаргасан, нөхцөлтэй бүртгэлтэй, андеррайтер компаниа сольсон зэрэг шалтгаанаар шалгагдах шаардлагатай 13 үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд 2024 оны 7-р сарын 09-ний өдрөөс 2024 оны 9-р сарын 27-ны өдрийг хүртэлх хугацаанд амжилттай зохион байгууллаа.

Хяналт шалгалтын явцад биржийн бус зах зээлийн үйл ажиллагаанд үнэт цаас гаргагчийн эрх зүйн зохицуулалт, хяналт, мэдээллийн ил тод байдал болон зуучлалын үйл ажиллагааны гүйцэтгэлийн байдлыг үнэлж, цаашид сайжруулах арга хэмжээний талаар санал дүгнэлт гаргаж, зохих зөвлөмжийг хүргүүлээ.



Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны чиглэлээр



2024

MINING WEEK & MINEPRO 2024



Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциациас 2024 оны 10-р сарын 2-5-ны өдрүүдэд зохион байгуулсан "Mining Week & MinePro 2024" олон улсын уул уурхайн үзэсгэлэн, чуулга уулзалтад Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо болон Биржийн бус зах зээлийн бүртгэлийн нэгж оролцлоо.

Тус арга хэмжээний үеэр Биржийн бус зах зээлээс хэрхэн богино хугацаанд санхүүжилт татах боломжийг танилцуулсан юм. Мөн Холбооны Гадаад харилцаа, хамтын ажиллагааны захирал Э.Мөнх-Өргөө СММ танхимд "Биржийн бус зах зээл" сэдвээр илтгэл тавьж, гадаад, дотоодын олон мэргэжилтнүүдэд үйл ажиллагааны талаарх мэдээллийг хүргэлээ.



Most Active Underwriters

January 2025

Company	Amount
Invescore Capital	MNT 318,950,000,000
BDSec	MNT 308,000,000,000
Tavan Bogd Capital	MNT 29,240,000,000

Most Active Brokers

January 2025

Company	Amount
Golomt Capital	MNT 68,830,819,984.29
Mandal Capital Markets	MNT 17,299,045,064.66
Tavan Bogd Capital	MNT 17,251,532,697.96

Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны чиглэлээр

2024

www.otc.mn платформын шинэчлэлт, систем хөгжүүлэлт



Биржийн бус зах зээлийн бүртгэлийн нэгж нь www.otc.mn платформын хөгжүүлэлт, шинэчлэлтийн хүрээнд шууд оролцогч байгууллагуудаас санал, хүсэлтийг авч, санал асуулгаар ирүүлсэн саналуудыг нэгтгэн, платформын хөгжүүлэлтийн багт хүргүүлж, хэрэгжүүлэх боломжтой өөрчлөлт, сайжруулалтуудыг амжилттай хийж гүйцэтгэлээ.

Энэхүү өөрчлөлтийн хүрээнд хийгдсэн онцлох шинэчлэлтүүдийг дурдвал:

- **Үнэт цаасны самбарын ангилал:** Үнэт цаасыг самбарын дагуу ангилж харах боломжийг нэвтрүүлсэн.
- **Андеррайтерийн тайлан:** Андеррайтерийн тайланг транч тус бүрээр оруулах шаардлагагүй болсон ба одоо нэг дор оруулах боломжтой.
- **Delist үнэт цаас:** Арилжаанаас хасагдсан (Delist) үнэт цаасыг хянах, харах боломжтой болсон.
- **Хоёрдогч зах зээлийн хяналт:** Хоёрдогч зах зээлд арилжаалагдах боломжтой болон боломжгүй үнэт цаасыг ялган хардаг болсон.

Эдгээр өөрчлөлт нь хөрөнгө оруулагчид, брокерууд болон зохицуулагч байгууллагуудад үнэт цаасны төлөв байдлыг илүү ойлгомжтой болгох, хянах боломжийг бүрдүүлж, арилжааны шийдвэр гаргахад чухал дэмжлэг үзүүлэх юм.



Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны чиглэлээр

2024

Анхны ногоон бонд “Ногоон ирээдүй” бондын цан цохих ёслол.



2024 оны 12-р сарын 04-ны өдөр "Төрийн банк" ХК нь Монгол Улсын дотоодын биржийн бус зах зээлд анхны ногоон бонд болох "Ногоон ирээдүй" бондыг гаргаж, цан цохих ёслолын арга хэмжээг зохион байгууллаа.

"Ногоон ирээдүй" бонд нь Монгол Улсын ногоон таксономи болон банкны Тогтвортой санхүүжилтийн хүрээний шалгуурт нийцсэн төслүүдийг санхүүжүүлэх зорилготой бөгөөд Биржийн бус зах зээлд анх удаа гаргасан ногоон бонд гэдгээрээ онцлог юм.

Бондын зарцуулалтаар сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний хэмнэлт, хог хаягдлын менежмент зэрэг байгаль орчинд ээлтэй төслүүдийг санхүүжүүлж, Монгол Улсын ногоон эдийн засгийн шилжилтэд хувь нэмэр оруулж байна. Энэхүү бонд нь 2030 он гэхэд банкны ногоон зээлийн багцыг нийт зээлийн багцын 10 хувьд хүргэх зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн чухал алхам юм.

Үнэт цаас гаргагч "Төрийн банк" ХК, андеррайтераар "БиДиСек ҮЦК" ХК ажиллалаа.

Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны чиглэлээр 2024

Арилжааны тайлан




Биржийн бус зах зээлд 2024 онд 95 үнэт цаас гаргагчийн, 131 өрийн хэрэгсэл бүртгэгдлээ. Үүнээс 1,781.9 тэрбум төгрөгийн өрийн хэрэгсэл бүртгэгдэж, 1,670.2 тэрбум төгрөг татан төвлөрүүлсэн байна. Харин ам.доллараар 91.8 сая ам.доллар бүртгэгдэж, 71.9 сая ам.доллар татан төвлөрүүлээ.




2024 он	ТЭРБУМ ТӨГРӨГ	САЯ АМ.ДОЛЛАР
Бүртгэгдсэн үнийн дүн	1,781.9	91.8
Татан төвлөрүүлэхээр зарласан	1,670.7	71.9
Татан төвлөрүүлсэн дүн	1,670.2	71.9

Бүртгэгдсэн үнийн дүн, татан төвлөрүүлсэн дүнгээр:

Бүртгэгдсэн бондыг 2023 оны үетэй харьцуулахад төгрөгөөр бүртгэгдсэн бонд 76.3 хувь, ам.доллараар бүртгэгдсэн бонд 23.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



(ЖИЛЭЭР, ТЭРБУМ ₮)				
	БҮРТГЭГДСЭН ДҮН	ХУВЬ	ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ДҮН	ХУВЬ
2021	652.0		256.9	
2022	734.6	12.7 ▲	655.9	155.3 ▲
2023	1,010.6	37.6 ▲	829.8	26.5 ▲
2024	1,781.9	76.3 ▲	1,670.2	101.3 ▲



(ЖИЛЭЭР, САЯ \$)				
	БҮРТГЭГДСЭН ДҮН	ХУВЬ	ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ДҮН	ХУВЬ
2021	12.0		12.0	
2022	0		0	
2023	74.5	521 ▲	33.5	179.2 ▲
2024	91.8	23.2 ▲	178.3	432.2 ▲


Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны чиглэлээр 2024

Арилжааны тайлан



Бүртгэгдсэн үнийн дүн, татан төвлөрүүлсэн дүн улирлаар:

IV улиралд төгрөгийн бондын нийт дүнгийн 52 хувь, татан төвлөрүүлсэн дүнгийн 59 хувийг "Нийслэлийн ЗДТГ" болон "Монгол Улсын Хөгжлийн Банк" ХХК-аас гаргасан бонд эзэлж байна.



(УЛИРЛААР, ТЭРБУМ ₮)				
	БҮРТГЭГДСЭН ДҮН	ХУВЬ	ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ДҮН	ХУВЬ
2021 Q1	178.0		207.5	
2022 Q2	536.7	201.5▲	500.7	141.3▲
2023 Q3	209.8	-60.9▼	226.6	-54.7▼
2024 Q4	857.5	308.7▲	735.5	224.6▲

Өгөөжийн муруй эргэн төлөгдөх хугацаагаар:

Идэвхтэй байгаа В самбарын хувьд 24 сарын дараа төлөгдөх бондын өгөөж 6 сарын дараа төлөгдөх бондын өгөөжөөс 0.82 хувиар өндөр байна. Харин С самбарын хувьд 24 сарын дараа төлөгдөх бондын өгөөж 6 сарын дараа төлөгдөх бондын өгөөжөөс 0.73 хувиар бага байна.

*Хөрөнгө оруулагчтай харилцан тохиролцон хүүг багаар тооцсон компаниудыг хасаж тооцсон болно.



В САМБАР	
6 сар	18.60%
12 сар	18.87%
18 сар	18.86%
24 сар	19.42%

С САМБАР	
6 сар	19.56%
12 сар	18.72%
18 сар	18.74%
24 сар	18.83%

Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны чиглэлээр 2024

Арилжааны тайлан




Бүртгэгдсэн үнийн дүн салбараар:

Тайлант хугацаанд бүртгэгдсэн бондыг салбараар ангилан үзэхэд нийт бондын 46.9 хувь нь санхүүгийн салбарт хамаарч байна. Санхүүгийн салбарын бондын 81.1 хувийг Банк бус санхүүгийн байгууллага, 18.2 хувийг банк, 0.7 хувийг Үнэт цаасны компани эзэлж байна.

Компанийн бонд: Салбараар



Санхүүгийн салбар:



САЛБАР	ХУВЬ	САЛБАР	ХУВЬ
Барилга	4.5	Үйлдвэрлэл	0.6
Боловсрол, эрүүл мэнд	0.1	Хөдөө аж ахуй	0.6
Мэдээлэл, холбоо	0.5	Худалдаа, үйлчилгээ	4.9
Уул уурхай	3.6	Эрчим хүч	38.4

САНХҮҮГИЙН САЛБАР	46.9
ББСБ	81.1
Банк	18.2
ҮЦК	0.7

Бүртгэгдсэн өрийн хэрэгсэл хугацаагаар:

Тайлант хугацаанд 3-12 сарын хугацаатай бонд 59 хувь, 18 сарын хугацаатай бонд 24 хувь, 24 сарын хугацаатай бонд 13 хувь, 36 ба түүнээс дээш сарын хугацаатай бонд 4 хувийг тус тус бүрдүүлээ.



ХУГАЦАА	ТРАНЧ	ЭЗЛЭХ ХУВЬ
3-12 сар	177	59%
18 сар	71	24%
24 сар	38	13%
36 ба түүнээс дээш	12	4%

Эргэн төлөлт:

Тайлант хугацаанд нийт 671.45 тэрбум төгрөг, 12 сая ам.долларын эргэн төлөлт хийгдсэн байна.

Биржийн бус зах зээл 2024

Биржийн бус зах зээлийн шууд оролцогч



Биржийн бус зах зээлийн арилжаанд оролцох эрх бүхий нийт 34 шууд оролцогч байгууллага бүртгэлтэй байна. Шууд оролцогч байгууллагуудад бүртгэлтэй шууд бус оролцогч хувь хүн 3425, хуулийн этгээд 339 байна.

3425
339

№	ШУУД ОРОЛЦОГЧ	АНДЕРРАЙТЕР	ДИЛЕР	БРОКЕР	ХОС
1	Өлзий энд Ко Капитал УЦК ХХК	✓	✓	✓	
2	Инвескор Капитал УЦК ХХК	✓	✓	✓	
3	Стандарт Инвестмент УЦК ХХК	✓	✓	✓	
4	Эм Ай Си Си УЦК ХХК	✓	✓	✓	
5	Ард Секюритиз УЦК ХХК	✓	✓	✓	
6	Гүүдсек УЦК ХХК	✓	✓	✓	
7	Голомт Капитал УЦК ХХК	✓	✓	✓	
8	Мирэ Эссэт Секьюритис Монгол УЦК ХХК	✓	✓	✓	
9	Би Ди Сек УЦК ХХК	✓	✓	✓	
10	Нэйшнл Сэкуритис УЦК ХХК	✓	✓	✓	
11	Апекс Капитал УЦК ХХК	✓	✓	✓	
12	Райнос Инвестмент УЦК ХХК	✓	✓	✓	
13	Ти Ди Би Секьюритис УЦК ХХК	✓	✓	✓	
14	Таван Богд Капитал УЦК ХХК	✓	✓	✓	
15	Мандал Капитал Маркетс УЦК ХХК	✓	✓	✓	
16	Новел Инвестмент УЦК ХХК	✓	✓	✓	
17	Лайфтайм Инвестмент УЦК ХХК	✓	✓	✓	
18	Эс Жи Капитал УЦК ХХК	✓	✓	✓	
19	Стоклаб Секьюритиз УЦК ХХК	✓	✓	✓	
20	Аргай Бест УЦК ХХК		✓	✓	
21	Монсек УЦК ХХК		✓	✓	
22	Алтан хоромсог УЦК ХХК		✓	✓	
23	Ди Эйч Капитал УЦК ХХК		✓	✓	
24	Булган брокер УЦК ХХК		✓	✓	
25	Тэнгэр Капитал УЦК ХХК	✓		✓	
26	Мазаалай капитал партнерс УЦК ХХК	✓		✓	
27	Эс Жи Инвестмент Энд Секьюритис УЦК ХХК	✓		✓	
28	Нэтсэк УЦК ХХК			✓	
29	Үнэт Секьюритис УЦК ХХК			✓	
30	Бумбат Алтай УЦК ХХК			✓	
31	Тээвэр хөгжлийн банк ХХК	✓			
32	Голомт банк ХК	✓			
33	Би Жи Эм тогтмол орлогын багц хувийн ХОС ХХК				✓
34	Инвескор Ри Сайкл Хувийн ХОС ХХК				✓

СУРГАЛТ СУДАЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

 MASD



Сургалт судалгааны чиглэлээр 2024

Үнэт цаасны зах зээлд хугацаагүй мэргэшлийн ажил үйлчилгээ явуулах эрхтэй мэргэжилтнүүдэд дурсгалын гэрчилгээ гардууллаа.



Монгол улсад хөрөнгийн зах зээлийн анхны арилжаа зохион байгуулагдсан өдрийг тохиолдуулан Санхүүгийн Зохицуулах Хорооны удирдлагууд болон Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо нь үнэт цаасны зах зээлд хугацаагүй мэргэшлийн ажил үйлчилгээ явуулах эрхтэй мэргэжилтнүүдээ хүлээн авч дурсгалын гэрчилгээ гардууллаа.

Санхүүгийн Зохицуулах Хорооны дарга Д.Баярсайхан "Үнэт цаасны тухай анхны хууль 1994 онд батлагдсанаар Үнэт цаасны хороо байгуулагдаж, Монгол Улсад хөрөнгийн зах зээл, түүнийг зохицуулж, хяналт тавих төрийн байгууллага болон түүнд оролцогч мэргэжлийн байгууллагууд байгуулагдаж, цаашдын хөгжлийнхөө суурийг тавьж байсан билээ. Үүнээс хойш 30 жилийн хугацаанд хөрөнгийн зах зээл нь цоо шинэ түвшинд хүрч хөгжиж, олон шинэ бүтээгдэхүүнтэй, идэвхтэй арилжаатай, дэд бүтэц, технологи, хууль эрх зүйн хувьд олон улсын жишигтэй хөл нийлүүлсэн, шинэ өнгө төрх бүхий орчин үеийн зах зээл болж хөгжсөн байна" хэмээн онцоллоо.

Мөн МҮЦАЭХ нь "Тасралтгүй Боловсрол Судалгааны Институт"ХХК-тай Үнэт цаасны зах зээлийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах зорилгоор хамтран ажиллах гэрээ байгууллаа. "Тасралтгүй Боловсрол Судалгааны Институт"ХХК нь CFA I болон II түвшний сургалтад үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ явуулах эрхтэй мэргэжилтнүүдэд дараах хөнгөлөлтүүдийг олгож байгаа бөгөөд төлбөрийн уян хатан нөхцөлийг санал болгож байна.

1. Үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ явуулах эрхийн гэрчилгээг анх удаа авсан бол 5%;
2. Үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ явуулах эрхийн гэрчилгээ анх удаагаа сунгуулсан бол /4 жил/ 10%;
3. Үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ явуулах эрхийн гэрчилгээ хоёр дахь удаагаа сунгуулсан бол /6 жил/ 15%;
4. Үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ явуулах эрхийн гэрчилгээг гурав дахь удаагаа Хугацаагүй сунгасан бол 20% тус тус хөнгөлөлт эдлэхээр боллоо.



Сургалт судалгааны чиглэлээр 2024

Үнэт цаасны зах зээлийн анхан шатны сургалт



Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо нь Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хороо нартай хамтран "Олон нийтийн санхүүгийн боловсролыг дэмжих хөтөлбөр"-ийн хүрээнд "Хөрөнгийн зах зээлийн анхан шатны сургалт"-ыг дараах өдрүүдэд амжилттай зохион байгууллаа.

- 2024 оны 5-р сарын 07, 09
- 2024 оны 5-р сарын 14, 16, 21, 23

Суралцагчдад хөрөнгийн зах зээлийн өнөөгийн байдал, бодлого зохицуулалтын орчин, эдийн засгийн үндсэн ойлголт, Санхүүгийн болон үнэт цаасны зах зээл, Үнэт цаасны тухай ойлголт, түүний төрөл, Үнэт цаас гаргах, арилжаалах, Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчид, Үнэт цаасны зах зээлийн эрхзүйн зохицуулалт, Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, Олон улсын үнэт цаасны зах зээл, Финтек ба крипто валют гэсэн сэдвүүдийн хүрээнд боловсрол олгосон юм.




Сургалт судалгааны чиглэлээр 2024


Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрх олгох, аттестатчилах сургалт



2024 онд эрх олгох сургалтыг 1-р сар, 6-р сар болон 10-р сард 3 удаа зохион байгуулсан бөгөөд үнэт цаасны зуучлалын чиглэлээр 75 хүн сургалтад хамрагдаж 43 иргэн, Хөрөнгө оруулалтын чиглэлээр 219 хүн сургалтад хамрагдаж, 174 иргэн шалгалтад тэнцэж 3 жилээр үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ явуулах эрхээ авлаа.



Аттестатчиллаар 161 мэргэжилтэн сургалтад хамрагдаж 84 мэргэжилтэн 4 жилээр, 16 мэргэжилтэн 6 жилээр, 23 мэргэжилтний эрхийг хугацаагүйгээр тус тус сунгав. Холбоо нь "Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрх олгох, аттестатчилах сургалтыг 2011 оноос хойш 40 удаа зохион байгуулсан бөгөөд нийт 4,299 хүнд хөрөнгө оруулалт, үнэт цаасны зуучлалын эрхийг шинээр олгосон бөгөөд эрх нь хүчинтэй байгаа 2,071 мэргэжилтэн ажил, үйлчилгээ явуулж байна.





Сургалт судалгааны чиглэлээр

2024

Мэргэжилтнүүдийн “Тангараг өргөх ёслолын үйл ажиллагаа”



Монгол улсын үнэт цаасны зах зээлд мэргэшлийн ажил үйлчилгээ явуулах эрх олгох, аттестатчилах сургалтын шалгалтад тэнцсэн мэргэжилтнүүдийн тангараг өргөх ёслолын арга хэмжээг 2 удаа зохион байгууллаа.

1. 2024 оны 1-р сарын 30-ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх Мэргэшлийн зөвлөлтэй хамтран зохион байгуулсан уг сургалтад нийт 91 мэргэжилтэн хамрагдаж, 72 мэргэжилтэн тэнцэж, үнэт цаасны зах зээлд мэргэшлийн ажил үйлчилгээ явуулах эрхээ гардан авч, тангаргаа өргөлөө.

2. 2024 оны 6-р сарын 25 -ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх Мэргэшлийн зөвлөлтэй хамтран зохион байгуулсан уг сургалтад нийт 183 мэргэжилтэн хамрагдаж, 148 мэргэжилтэн тэнцэж, үнэт цаасны зах зээлд мэргэшлийн ажил үйлчилгээ явуулах эрхээ гардан авч, тангаргаа өргөлөө. Энэ сургалтаар УУББ-ийн тухай хуульд заасан биржийн зуучлагч (брокер)-ын чиглэлээр 43 мэргэжилтэнд эрх олголоо.

3. 2024 оны 11-р сарын 25-ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх Мэргэшлийн зөвлөлтэй хамтран зохион байгуулсан уг сургалтад нийт 205 мэргэжилтэн тэнцэж, үнэт цаасны зах зээлд мэргэшлийн ажил үйлчилгээ явуулах эрхээ гардан авч, тангаргаа өргөлөө. Энэ удаагийн сургалтаар мөн Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд заасан биржийн зуучлагч (брокер)-ын чиглэлээр 25 мэргэжилтэнд эрх олголоо.

2024 онд компанийн
засаглалын цахим сургалтад
52 хүн хамрагдаж, гэрчилгээ
авлаа.

•
•

ГИШҮҮН БАЙГУУЛЛАГА, МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ЭРХ
АШИГ, ЧАДАВХЫГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР

•

 MASD



Гишүүн байгууллага, мэргэжилтнүүдийн эрх ашиг, чадавхыг сайжруулах чиглэлээр

2024



"Миний дуртай үнэт цаасны эрх зүй клуб"

Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны гишүүн байгууллагуудын хуульч, эрх зүйч, комплаенс мэргэжилтнүүдийн гишүүнчлэлтэй "МИНИЙ ДУРТАЙ ҮНЭТ ЦААСНЫ ЭРХ ЗҮЙ КЛУБ"-г 2023 онд амжилттай үүсгэн байгуулсан. Тус клубийн Ерөнхий зохицуулагчаар СЭЗИС-ийн санхүү, банк, үнэт цаасны эрх зүйн гэрээт багш Б.Ган-Эрдэнэ, зохицуулагчаар "Кэй и Партнерс" ХХН-ийн партнер М.Лхамсүрэн, "Таван Богд Капитал ҮЦК" ХХК-ийн хуулийн зөвлөх Б.Учралбаяр, Easy цахим сургалтын үүсгэн байгуулагч Б.Цолмон нар ажиллахаар сонгогдсон юм.

Клуб нь 2024 онд нийт 3 удаагийн уулзалтыг амжилттай зохион байгуулаад байна.

Үүнд:

1. 2024 оны 3-р сарын 05-ны өдөр "Арбитрын эрх зүйн зохицуулалт ба үнэт цаасны зах зээл" сэдвийн хүрээнд Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс ХХН, гишүүн партнер Д.Дүгэржав болон "Үнэт цаасны маргааныг арбитрын журмаар шийдвэрлэх олон улсын практик сэдвээр МУИС-ийн ахлах багш, Хууль зүйн доктор М.Мөнхнаран;
2. 2024 оны 5-р сарын 17-ний өдөр "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжид оруулж буй нэмэлт өөрчлөлт" сэдвийн хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Ж.Мөнх-Оргил;
3. 2024 оны 11-р сарын 20-ний өдөр "Нотариатын мэдэгдэх хуудас ба Үнэт цаасны зах зээл" сэдвээр Монголын Нотариатчидын Танхимын Ерөнхийлөгч, Хууль зүйн ухааны доктор, дэд профессор Азийн нотариатын холбооны Ерөнхийлөгч Ч.Баянжаргал.



Гишүүн байгууллага, мэргэжилтнүүдийн эрх ашиг, чадавхыг сайжруулах чиглэлээр

2024



“Үнэт цаасны салбарын нягтлан бодогчдын клуб”

Холбооны зорилтын хүрээнд Үнэт цаасны компаниудын нягтлан бодогчдын уялдаа холбоог сайжруулах, харилцан суралцах зорилгоор гишүүн байгууллагын нягтлан бодогчдын гишүүнчлэлтэй “Үнэт цаасны салбарын нягтлан бодогч нарын клуб”-ыг үүсгэн байгууллаа. Уг клубын ерөнхий зохицуулагчаар “Ти Ди Би Секьюритис ҮЦК” ХХК-ийн Номинал данс хариуцсан менежер Б.Батхишиг, клубын чиглүүлэгчээр Монголын үндэсний тайлагнал аудитын фирмийн Партнер С.Баярхүү нар ажиллахаар сонгогдсон юм.

Клуб нь 2024 оны хагас жилд нийт 2 удаагийн уулзалтыг амжилттай зохион байгуулаад байна.

Үүнд:

- 2024 оны 1-р сарын 30-ны өдөр “Жилийн эцсийн тайлан, И-такс” сэдвээр Татварын ерөнхий газрын, Татвар төлөгчид үйлчлэх газар, Татварын улсын байцаагч Ц.Ундармаа;
- 2024 оны 5-р сарын 28-ны өдөр “PWC Mongolia” ХХК-ийн Татварын ахлах менежер Ж.Энхзул.



Гишүүн байгууллага, мэргэжилтнүүдийн эрх ашиг, чадавхыг сайжруулах чиглэлээр

2024



“Хөрөнгө оруулалт менежментийн компаниудын өглөөний уулзалт”

Холбооны ажлын алба болон Удирдах зөвлөлийн төлөөллүүд 2024 оны 9-р сарын 5-ны өдөр хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг тогтвортой хөгжүүлэх зорилгоор хөрөнгө оруулалт менежментийн компаниудын төлөөллүүдтэй уулзлаа.

Уулзалтаар зах зээлийн дүрэм, журмуудын өөрчлөлт, хөрөнгө оруулалтын менежмент компани болон хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлаар нээлттэй чөлөөт хэлэлцүүлэг өрнүүллээ.

Уулзалтын үр дүнд Холбооноос хөрөнгө оруулалт менежментийн компанийн үйл ажиллагааг дэмжиж, санал хүсэлтийг нэгтгэн цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг ХОМК, ХОС-ын төлөөллүүдтэй хамтран Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг тогтвортой хөгжүүлэх зорилготой ажлын хэсэг байгуулагдахаар боллоо.



Гишүүн байгууллага, мэргэжилтнүүдийн эрх ашиг, чадавхыг сайжруулах чиглэлээр

2024

“Гишүүн байгууллагуудын удирдан манлайлагч эмэгтэйчүүдийн уулзалт”



Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбооноос “Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан гишүүн байгууллагуудын эмэгтэй захирлуудтай өглөөний уулзалт зохион байгууллаа. Уулзалтаар Холбооны гишүүн байгууллагуудын хүрээнд 29 эмэгтэй захирал, нийт 200 гаруй эмэгтэй ажилчид байгаа нь гишүүн байгууллагуудын ажилчдын 60 гаруй хувийг эмэгтэй ажилчид эзэлж байгааг онцолсон юм.

Мөн “Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан салбарын мэргэжилтнүүддээ урам зориг өгөх зорилгоор Хөрөнгийн зах зээлд манлайллаараа тэргүүлж байгаа удирдлагуудын төлөөллүүдийн ярилцлага бүхий товхимлыг бэлтгэн хүргүүлсэн юм.

Товхимлыг үзэх:





Гишүүн байгууллага, мэргэжилтнүүдийн эрх ашиг, чадавхыг сайжруулах чиглэлээр

2024

“Дилерүүдийн өдөр”-ийг тохиолдуулан зохион байгуулсан “Цан цохих ёслол”



Монгол Улсад хөрөнгийн зах зээлийн анхны арилжаа зохион байгуулагдсан өдөр буюу “Дилерүүдийн өдөр”-ийг тохиолдуулан Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо, Монголын хөрөнгийн бирж болон Холбооны дэргэдэх “Ахмадын зөвлөл”-ийн гишүүд МХБ-ийн 7149 дахь арилжааг нээж цан цохилоо.

МХБ-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Цогтбаяр үйл ажиллагааг нээж хэлсэн үгэндээ: “Монгол Улсын Засгийн газрын 22 тоот тогтоолоор 1991 онд улсын өмч хувьчлалын ажлыг эхлүүлэх, үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх зорилгоор МХБ-ийг үүсгэн байгуулсан. Өнгөрөгч 30 гаруй жил Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн тvvхэн үйл явц өрнөхөд өөр өөрсдийн эрдэм мэдлэг, хичээл зүтгэлээр үнэ цэнийг бүтээсэн та бүхэнд энэ өдөр онцгойлон талархал илэрхийлж, баяр хүргэе” гэв.

Холбооны Удирдах зөвлөлийн дарга Ц.Наран-Учрал: “Тэртээ 1992 оны 2-р сарын 07-ны өдөр Монгол Улсад үнэт цаасны арилжаа гэдэг шинэ үйлчилгээ нэвтэрч, энэ танхимд бүх зүйл шинээр эхэлж байсан. Энэхүү зах зээлийн шинэ салбарын үүслийг тавьсан шинэхэн мэргэжилтнүүд өнөөдөр 30 гаруй жилийн тэртээх өдрүүдийг дурсаж байна. Өнөөдөр бол Үнэт цаасны зах зээлийн анхны арилжаа эхэлсэн онцгой өдөр. Үе үеийн дилерүүддээ баяр хүргэж, амжилт хүсье” хэмээн хэллээ.

Ахмадын зөвлөлийн тэргүүлэгч Б.Баатархуяг МХБ-ийн дурсгалын дэвтэрт тэмдэглэхдээ: “1991 онд Үнэт цаасны брокерын пүүсийн 3 сарын дамжаанд суралцаж нийслэл, аймаг, орон нутагт брокерын пүүс байгуулан, үнэт цаасны зах зээлийн тулганы чулууг тавилцсан хамт олондоо арилжаа эхэлсний 33 жилийн ойн баярын мэнд хүргэе” гэж бичиж, сэтгэгдлээ хуваалцсан юм.



Гишүүн байгууллага, мэргэжилтнүүдийн эрх ашиг, чадавхыг сайжруулах чиглэлээр

2024

Хөрөнгийн зах зээлийн судалгааг дэмжих, судалгааны грант хөтөлбөр



Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо нь дүрэмд заасан чиг үүргийнхээ хүрээнд гишүүдийн үйл ажиллагаа, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх бодлогын дэмжлэг үзүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах, мэргэжлийн зөвлөгөө, мэдээллээр хангах зорилгоор "Capital Markets Mongolia"-тай хамтран Монголын хөрөнгийн зах зээлийн судалгааг дэмжих, судалгааны грант хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр гурван талт гэрээ байгууллаа. Хөтөлбөрийн үр дүнд шинжээч Д.Болортуяа, шинжээч Р.Дарханбаяр нар сонгогдож, судалгааны ажлыг хариуцан гүйцэтгэхээр боллоо.

Шинжээч Д.Болортуяа нь "Хувийн тэтгэврийн санг Монгол Улсад нэвтрүүлэх нь" сэдэвт судалгааны ажлыг гүйцэтгэх бөгөөд уг судалгаа нь Монгол Улсад хувийн тэтгэврийн сангийн онцлог, боломжит үр нөлөө, олон улсын туршлагыг дүгнэн гаргахад чиглэгдсэн. Энэ нь Монголын санхүүгийн зах зээлд хувийн тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэхэд шаардлагатай нөхцөлүүдийг тодорхойлох, хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой.

Шинжээч Р.Дарханбаяр нь "Хэрхэн амжилттай IPO гаргах, сүүлийн 10 IPO-н харьцуулсан судалгаа" сэдэвт судалгааны ажлыг гүйцэтгэх бөгөөд уг судалгаа нь амжилттай IPO гаргах арга замуудыг тодорхойлж, сүүлийн 10 IPO-гийн туршлага болон үр дүнг харьцуулан шинжлэх замаар үнэт цаасны зах зээлийн зохицуулалтыг сайжруулах, хөрөнгө оруулалтын орчныг өргөжүүлэхэд чиглэгдсэн.

МҮЦАЭХ болон "Capital Markets Mongolia"-тай хамтарсан энэхүү судалгаанууд нь Холбооны гишүүн байгууллагуудыг мэргэжлийн зөвлөгөө, мэдээллээр хангах, тэдний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, зах зээлийн хөгжлийг дэмжихэд чухал хувь нэмэр оруулах зорилготой байна.



Гишүүн байгууллага, мэргэжилтнүүдийн эрх ашиг, чадавхыг сайжруулах чиглэлээр

2024

2024 онд бэлтгэн хүргэсэн товхимол, судалгаа



Тогтвортой Хөгжлийн
Бондын Удирдамж:
Монгол хэлний
орчуулга;



Уур амьсгалын
шилжилтийн санхүү:
Монгол хэлний
орчуулга;



Нийгмийн Бондын
Зарчим:
Монгол хэлний
орчуулга;



Биржийн бус зах зээл,
Барилгын салбарын
судалгаа;



Биржийн бус зах зээл,
Банк бус санхүүгийн
байгууллагын
салбарын судалгаа;



Хууль, Эрх зүйн тойм
мэдээлэл 2024 он;
Миний дуртай Үнэт
цаасны эрх зүй клуб



Тусгай товхимол 1: "Олон
улсын эмэгтэйчүүдийн
эрхийг хамгаалах өдөр"
товхимол;



Тусгай товхимол 2:
Үнэт цаасны зах
зээлийн тухай хуульд
нэмэлт өөрчлөлт;



Биржийн бус зах
зээлийн товхимол
2024 оны I, II, III, IV
улирал;



Тэтгэврийн
реформыг зөв
эхлүүлэх нь
судалгаа [MN] [ENG].



Гишүүн байгууллага, мэргэжилтнүүдийн эрх ашиг, чадавхыг сайжруулах чиглэлээр

2024

Холбооны гишүүн байгууллагын эдлэх хөнгөлөлтүүд



10% OFF

"Монголын хөрөнгийн бирж" ХК

"Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн гишүүн нь Холбооны гишүүн бол МХБ-ийн жилийн үйлчилгээний хөлсөөс 10 хувиар хөнгөлж хамтран ажиллаж байна.

15% OFF

"Лимон пресс дижитал" ХХК

Холбооны гишүүн байгууллагуудад 3-4 бүтээгдэхүүн үйлчилгээнд 15% хөнгөлөлт үзүүлэх бөгөөд 1 жилийн гэрээг тодорхой дүнгээс дээш байгуулсан тохиолдолд бүх бүтээгдэхүүн үйлчилгээнд 10% хөнгөлөлт үзүүлэхээр хамтран ажиллаж байна.

10% OFF

"Кэй И Партнерс" ХХН

20% OFF

"Кэй И Партнерс" ХХН-ийн партнер М.Лхамсүрэн нь Холбооны дэргэдэх "Миний дуртай үнэт цаасны эрх зүй клуб"-ын зохицуулагчаар ажилладаг бөгөөд Холбоонд хууль зүйн мэдээ бэлтгэн өгч хамтран ажиллаж байна.

10% OFF

"Өмгөөллийн фиделитас партнерс" ХХН

20% OFF

Гишүүн байгууллагын нийтлэг асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн хууль зүйн мэдээлэл өгөх, сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, зохицуулалтын орчны тодруулга, тайлбар өгөх хүрээнд хамтран ажиллаж байна.

5% OFF

"ЭМ БИ ВИ СИ Үнэлгээ" ХХК

15% OFF

"Эм Би Ви Си Үнэлгээ" ХХК нь хөрөнгийн үнэлгээ, бизнесийн үнэлгээ хийх чиглэлээр ажилладаг бөгөөд Холбооны хамтрагч гишүүн байгууллага юм.

5% OFF

"Тасралтгүй Боловсрол Судалгааны Институт" ХХК

20% OFF

"Тасралтгүй Боловсрол Судалгааны Институт" ХХК нь CFA I болон II түвшний сургалтад үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ явуулах эрхтэй мэргэжилтнүүдэд төлбөрийн уян хатан нөхцөлийг санал болгоно.



Гишүүн байгууллага, мэргэжилтнүүдийн эрх ашиг, чадавхыг сайжруулах чиглэлээр

2024

Холбооны гишүүн байгууллагын эдлэх хөнгөлөлтүүд



"Хүлэгт хүннү аудит" ХХК

"Хүлэгт хүннү аудит" ХХК нь Холбооны гишүүн байгууллагуудад зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр хамтран ажиллаж байна.

"Интер аудит" ХХК

"Интер аудит" ХХК нь Холбооны гишүүн байгууллагуудад зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр хамтран ажиллаж байна.

60%
OFF

"Грэйпсити монгол ХК, Мост финтек ХХК

Грэйпсити монгол ХК, Мост финтек ХХК нь Холбооны гишүүн бол КАСПО системийг нэвтрүүлсэн тохиолдолд элсэлтийн хураамж, нэвтрүүлэх ажлын төлбөр болон үйлчилгээний сарын хураамжид 60% хүртэл хөнгөлөлт олгоно.

30%
OFF

"Интеллигент финанс" ххк

Интеллигент финанс ХХК нь Холбооны гишүүн байгууллагуудад "iStock ERP" буюу ҮЦК-ийн суурь систем нэвтрүүлэлтийн үйлчилгээний хураамжаас 30% хөнгөлөлт олгоно.

10%
OFF

"Консепт интернэшнл" ХХК

Консепт интернэшнл ХХК-тай Холбоо нь монголын хөрөнгө оруулалтын зах зээлийг тэлэх ажлуудыг хамтран хэрэгжүүлэх зорилготой санамж бичиг байгуулсан бөгөөд Холбооны гишүүн байгууллагуудад 10% хүртэл хөнгөлөлт олгоно.

20%
OFF

"Смарт Контракт Монголиа" ХХК

Смарт Контракт Монголиа ХХК-тай Холбоо нь үнэт цаасны зах зээлийг цахимжуулах, үйл ажиллагааг хялбар, хурдан, найдвартай болгох зорилгоор хамтын ажиллагааны гэрээ байгуулсан бөгөөд Холбооны гишүүн байгууллагуудад 20%-50% хүртэл хөнгөлөлттэй үнэ санал болгоно.

50%
OFF



Гишүүн байгууллага, мэргэжилтнүүдийн эрх ашиг, чадавхыг сайжруулах чиглэлээр

2024



“MASD SUMMER FESTIVAL-2024”

Холбооны гишүүн байгууллагууд болон хөрөнгийн зах зээлийн мэргэжилтнүүдийн харилцаа холбоог бэхжүүлэх, эрч хүчээр цэнэглэх зорилгоор “MASD SUMMER FESTIVAL 2024” арга хэмжээг 6-р сарын 14-ний өдөр амжилттай зохион байгуулагдлаа.

Хөрөнгийн зах зээлийн 300-аад мэргэжилтнүүд хоорондоо танилцан, өдөр тутмын завгүй ажлаасаа завсарлага авч тархиа амраан цагийг хөгжилтэй өнгөрүүлж, байгалийн үзэсгэлэнт газраар явган аялж, морь унаж, зураг зурсан юм.

Мөн арга хэмжээний үеэр Хөрөнгийн зах зээлийн анхны 3х3 сагсан бөмбөгийн тэмцээн, Элсний волейболын тэмцээнийг зохион байгуулж, дараах аварга багуудыг шалгарууллаа.

3х3 сагсан бөмбөг:

Алтан медаль- “Монголын хөрөнгийн бирж” ХК

Мөнгөн медаль- “Голомт капитал ҮЦК” ХХК

Хүрэл медаль- “Нэтсэк ҮЦК” ХХК

Элсний волейбол:

Алтан медаль-“Голомт капитал ҮЦК” ХХК

Мөнгөн медаль-“Инвескор капитал ҮЦК” ХХК

Хүрэл медаль-“БиДиСЕК ҮЦК”ХХК

Хамтран зохион байгуулагч:

- “Үнэт цаасны зах зээлийн маркетингуудын клуб”
- “БиДиСЕК ҮЦК” ХХК
- “Улаанбаатар Үнэт Цаасны Бирж” ХК
- “Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ХХК
- “Монголын Үнэт Цаасны Клирингийн Төв” ХХК



Гишүүн байгууллага, мэргэжилтнүүдийн эрх ашиг, чадавхыг сайжруулах чиглэлээр

2024



ҮНЭТ ЦААСНЫ ТӨВЛӨРСӨН
ХАДАЛАМЖИЙН ТӨВ

Хөрөнгийн зах зээлд оролцогч байгууллагуудын “Спортын их наадам 2024”

Монголын хөрөнгийн зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудын дунд уламжлал болгон зохион байгуулагдаж ирсэн “Спортын их наадам 2024” арга хэмжээг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв нь 2024 оны 1-р сарын 13-ны өдрөөс 1-р сарын 21-ны өдрүүдэд зохион байгууллаа. Холбоо нь Монголын хөрөнгийн зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудад ажиллаж буй мэргэжилтнүүдийн хамтын ажиллагаа, тэдний бие бялдрыг чийрэгжүүлэх, спортоор хичээллэн эрүүл мэндээ сайжруулахад хувь нэмрээ оруулах, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, спортын талбарт шударгаар өрсөлдөх, спортын шилдгүүдийг алдаршуулах зорилго дор тэмцээний ерөнхий зохион байгуулагчаар хамтарч ажилласан.

Энэ удаагийн тэмцээний онцлог нь уламжлалт спортын таван төрөлт тэмцээн дээр “Хийн буудлага”-ын спортын төрлийг нэмж оруулсан нь юм.

Холбооны баг нь гишүүн байгууллагуудын мэргэжилтнүүдээс бүрэлдүүлж орсон ба байр эзэлсэн мэдээллийг хүргэв.

- “Шатар”-ын төрөлд “Тэргүүн байр”
- “Гарбөмбөг” – ийн төрөлд “Дэд байр”
- “Ширээний теннис”-ийн төрөлд “Дэд байр”

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭЭНД

The logo for MASD is embossed in silver on a red textured surface. It features a stylized 'M' icon composed of three horizontal bars of increasing length, followed by the letters 'A', 'S', and 'D' in a bold, sans-serif font.

MASD



Нийгмийн хариуцлагын хүрээнд

“Малчдад туслах хандивын аян”



Монгол Улсын нийт нутгаар хаваржилтын нөхцөл нэн хүнд, байгаль цаг агаарын хүндхэн үе тохиож малчдын амьжиргаанд хүндрэл тулгарч байгаа цаг үед Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооноос нийт гишүүн байгууллагууддаа “Малчдад туслах хандивын аян”-д нэгдэхийг уриалж Холбоо болон 14 гишүүн байгууллагаас мөнгөн хандив цугларсныг Улсын онцгой комисст хүлээлгэн өглөө.

Үндэсний аюулгүй байдал, хүн ам, нийгэм эдийн засагт сөрөг үр дагавар учруулж байгаа гамшигтай тэмцэх үйлсэд хувь нэмрээ оруулан, төр засгийн шийдвэрийг бүх талаар дэмжиж, малчин ард иргэддээ туслах аянд нэгдэж хандив илгээсэн гишүүн байгууллагууддаа талархал илэрхийлье.

- Өлзий энд Ко капитал ҮЦК
- Mirae Asset Securities Mongolia UTsK
- TDB Securities SC
- Standard Investment LLC
- Apex Capital - Better Investing
- Mandal Capital
- Rhinos Investment
- BGM Asset Management
- TenGer Capital
- Гүүдсек Үнэт Цаасны Компани
- Golomt Capital
- Бумбат Алтай ҮЦК / Bumbat Altai brokerage
- Таван Богд ҮЦК
- MDS KhanLex LLP | Өмгөөллийн "ЭмДиЭс ХаанЛекс" ХХН



Нийгмийн хариуцлагын хүрээнд 2024

“Тэрбум мод-Үндэсний хөдөлгөөн”



Санхүүгийн зохицуулах хорооноос “ТЭРБУМ МОД-ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН”-ний хүрээнд зохицуулалттай салбарын байгууллагын төлөөллүүд хамтран “Олон улсын эко цэцэрлэгт хүрээлэн”-д 1300 гаруй мод тарих арга хэмжээг амжилттай зохион байгууллаа.

Олон улсын эко цэцэрлэгт хүрээлэнд 2024 оны хаврын тариалангийн хүрээнд 5 га талбайд нийт 24,000 мод таригдсан бөгөөд Холбооны Удирдах зөвлөлийн төлөөллүүд болон гишүүн байгууллага “Апекс капитал” ҮЦК, “БиДиСек” ҮЦК, “Голомт капитал” ҮЦК, “Гүүдсек” ҮЦК, “Инвескор капитал” ҮЦК, “Мандал капитал” ҮЦК, “Ти Ди Би Секьюритис” ҮЦК, “Стандарт инвестмент” ҮЦК, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК нар оролцож мод тарилаа.

“Тэрбум мод” тарих үндэсний хөдөлгөөнд салбарынхны оролцоог нэмэгдүүлэх санал санаачилгыг дэмжиж, Монгол Улс төдийгүй дэлхийн дулаарлын эсрэг олон улсын зорилго зорилт, ойн тогтвортой менежмент, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон ойн экосистемийг бий болгон нүүрстөрөгчийн хуримтлалыг нэмэгдүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулсан гишүүн байгууллагууддаа талархал илэрхийлье.



Нийгмийн хариуцлагын хүрээнд

“БУХЫН ХӨШӨӨ” урлан, бүтээн байгуулалт



Монголбанкны 100 жил, Санхүүгийн зохицуулах хороо байгуулагдсаны 30 жилийн ойг тохиолдуулан Санхүүгийн салбарын байгууллагуудын санаачилгаар, Цэцэг төвөөс Зоос гоёл хүртэлх гудамжинд Цаг уурын эсрэг талд Хөрөнгийн зах зээлийн бэлгэдэл болсон Монголын уламжлалт өв соёл, зан заншлыг шингээсэн загвар бүхий БУХЫН ХӨШӨӨ урланг энэ оны 7-р сарын эхээр тохижуулж дуусахаар төлөвлөж бэлтгэл ажил хангагдаад байна. Энэхүү бүтээн байгуулалтыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Банкны холбоо, МҮЦАЭХ нар хамтран гүйцэтгэхээр шийдвэрлэсэн. Уг бүтээн байгуулалтад үнэтэй хувь нэмрээ оруулсан дараах Хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн байгууллагууд болон оролцогч байгууллагууддаа талархал илэрхийлье.

- Алтан хоромсог ҮЦК ХХК
- Апекс капитал ҮЦК ХХК
- Аргай бэст ҮЦК ХХК
- Өлзий энд Ко капитал ҮЦК ХХК
- Ард секюритиз ҮЦК ХХК
- Батс ҮЦК ХХК
- БиДиСек ҮЦК ХХК
- Бумбат-Алтай ҮЦК ХХК
- Гаули ҮЦК
- Голомт капитал ҮЦК ХХК
- Гранддевелопмент ҮЦК ХХК
- Гүүдсек ҮЦК ХХК
- Ди Эйч Капитал ҮЦК ХХК
- Нэтсэк ҮЦК ХХК
- Инвескор капитал ҮЦК ХХК
- Мандал Капитал Маркетс ҮЦК ХХК
- Мирэ Эссэт Секьюритис Монгол ҮЦК ХХК
- Монсек ҮЦК ХХК
- Райнос инвестмент ҮЦК ХХК
- Таван богд ҮЦК ХХК
- Таванбогд капитал ҮЦК ХХК
- Ти Ди Би СЕКЬЮРИТИС ҮЦК ХХК
- Тэнгэр капитал ҮЦК ХХК
- Эм Ай Си Си ҮЦК ХХК
- Стоклаб секьюритиз ҮЦК ХХК
- Ард менежмент ХХК
- Мандал Ассет Менежмент ҮЦК ХХК
- Сод ассет менежент ҮЦК ХХК
- Чингис хаан бирж
- МҮЦКТ ХХК

Хувьцаат компани:

- Газар шим ХК
- Түмэн шувуут ХК

2 $\approx$ 24 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо
Өөрийгөө зохицуулах байгууллагын 2024 оны үйл ажиллагааны тайлан